

ХЯТАДЫН ТЭТГЭЛЭГИЙН ЗӨВЛӨЛ

Хятадын засгийн газрын тэтгэлэгт өргөдөл гаргах гарын авлага

Зарлал: 622972

Хятад улс болон дэлхийн ард түмний харилцан ойлголцол, найрамдалт харилцааг бэхжүүлж, Хятад улс бусад оронуудтай олон төрлийн салбаруудад туршлага солилцох, хамтын ажиллагааг ахиулах зорилгоор Хятадын засгийн газар авъяаслаг оюутанууд болон эрдэмтдэд Хятадын их дээд сургуульд дээд боловсрол эзэмших эсвэл судалгаа хийх тэтгэлэг олгодог.

Хятадын боловсролын яамнаас итгэмжлэгдсэн Хятадын тэтгэлэгийн зөвлөл (цаашид "ХТЗ" гэх) нь Хятадын засгийн газрын тэтгэлэг хүлээн авагчдын элсэлт, сургуулийн бүртгэл, удирдлагын ажлыг хариуцдаг.

I. Тэтгэлэг болон өргөдөл

Их сургуулийн хөтөлбөр

Энэхүү хөтөлбөр нь Хятадын зорилтот их дээд сургуулиудаас шууд сонгон шалгаруулж, санал болгосон авъяаслаг олон улсын оюутнуудыг Хятадад сургах ажлыг санхүүжүүлэх зорилготой юм. Дэмжлэг үзүүлэх оюутны ангилал нь эдгээр их дээд сургуулиудын шаардлагаас шалтгаалан ялгаатай байдаг.

Өргөдөл гаргагч нь энэхүү хөтөлбөрийг хэрэгжүүлж буй Хятадын их дээд сургуулиудад өргөдөл гаргана.

II. Хугацаа, боловсролын байгууллага болон мэргэжил

Хугацаа

Хятадын Засгийн газрын Тэтгэлэг нь мэргэжлийн болон хятад хэлний (бэлтгэл) сургалтыг хамардаг. Хэлний сургалт нь нэг жил үргэлжилдэг бол мэргэжлийн сургалтын тэтгэлэг нь шаардлагтай хугацаанд үргэлжилнэ.

Боловсролын байгууллага болон мэргэжил

Хятадын зорилтот их дээд сургуулиуд тэтгэлэгт хамрагдагчдад шинжлэх ухаан, инженерчлэл, хөдөө аж ахуй, анагаах ухаан, эдийн засаг, хууль эрх зүй, менежмент, боловсрол, түүх, уран зохиол, гүн ухаан, дүрслэх урлаг зэрэг чиглэлээр боловсролын хөтөлбөрүүдийг санал болгодог. Хятадын зорилтот их дээд сургуулиуд болон тэдний санал болгож буй мэргэжлүүдийн талаар нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл <https://www.campuschina.org> веб сайтаар зочилно уу.

III. Тэтгэлэгийн хамрах хүрээ

1. Сургалтын төлбөр;
2. Их, дээд сургуулийн дотуур байрны төлбөрөөс чөлөөлөх эсвэл байрны тэтгэмж;
3. Стипент: Бакалавр: сар бүр CNY 2,500;
4. Эрүүл мэндийн цогц даатгал: хүн тус бүрт жил тутам CNY 800;

IV. Тавигдах шаардлага

Өргөдөл гаргагч нь шаардлага хангахын тулд:

1. БНХАУ-аас өөр улсын иргэн байх, сэтгэцийн болон бие махбодийн хувьд эрүүл байх;
2. бакалаврын хөтөлбөрт хамрагдах өргөдөл гаргахдаа 25-аас доош насны ахлах сургуулийн диплом эсвэл түүнтэй дүйцэхүйц төгсөлтийн гэрчилгээтэй байх;
3. Хятад хэлээр заадаг бакалаврын болон ерөнхий тэтгэлэгт хөтөлбөрт хамрагдахдаа HSK (3-р түвшний) тэнцсэн байх (хятад хэлний мэргэжлээр суралцахаас бусад);
4. Хятад хэлнээс өөр хэлээр заадаг хөтөлбөрт хамрагдахдаа тухайн их сургуулийн хэлний мэдлэг болон боловсролын ур чадварт тавигдах элсэлтийн шаардлагыг хангасан байх.

V. Өргөдөл гаргах үйл явц

1. Өргөдөл гаргагч нь <https://www.campuschina.org> эсвэл бусад хэрэгслээр дамжуулан БНХАУ-ын тогтоосон санал болгож буй их, дээд сургууль, мэргэжлүүдийн талаар мэдээллийг үзэж, хүсч буй тэтгэлэгт хөтөлбөр болон зорилтот их сургууль, мэргэжлээ тодорхойлно;
2. Өргөдөл гаргагч нь элсэлтийн бичиг баримтыг авахын тулд зорилтот их сургуультайгаа холбоо барина;

3. Өргөдөл гаргагч нь зөвлөмж зөвлөгөө авахын тулд өргөдөл хүлээн авагч байгууллагатай холбоо барина;
4. Өргөдөл гаргагч нь Хятадын засгийн газрын тэтгэлэгт хамрагдах өргөдлийн маягтыг Хятадын засгийн газрын тэтгэлгийн мэдээллийн систем буюу <https://www.campuschina.org> веб сайтаар зочилж онлайнаар бөглөж, ирүүлнэ;
5. Өргөдөл хүлээн авагч байгууллага нь санал болгож буй өргөдөл гаргагчдын жагсаалт болон өргөдлийн бичиг баримтыг ирүүлнэ;
6. Хятадын тэтгэлэгийн зөвлөл нь өргөдөл гаргагчдын богино жагсаалтыг эцэслэхээс өмнө өргөдөл гаргагчийн шаардлагад нийцсэн эсэх, болон боловсролын үзүүлэлтийг хянан шалгах зорилготой дээд сургууль болон мэргэжилтнүүдийг зохион байгуулна;
7. Хятадын тэтгэлэгийн зөвлөл нь элсэлтийн үр дүнг өргөдөл хүлээн авагч байгууллагад мэдэгдэх бөгөөд дараа нь өргөдөл гаргагчид мэдэгдэх болно.

VI. Өргөдлийн бичиг баримтууд

1. *Хятадын засгийн газрын тэтгэлэгт хамрагдах өргөдлийн маягт* (онлайнаар бөглөсөн);
2. Паспортын мэдээллийн хуудасны сканнердсан хуулбар. Өргөдөл гаргагч нь 2023 оны 3-р сарын 1-ний өдөр буюу түүнээс өмнө хүчинтэй хугацаа нь дуусаагүй паспортын мэдээллийн хуудасны сканнердсан ил тод хуулбарыг ирүүлнэ. Шаардлагыг хангаагүй тохиолдолд паспортоо сунгуулсан байх шаардлагатай. Өөрөөс хамаарахгүй шалтгаанаар паспорт авах хүсэлт гаргаж чадаагүй өргөдөл гаргагч нь өргөдөл хүлээн авагч байгууллагын зөвшөөрлөөр өргөдөл гаргагчийн англи үсгээр бичсэн бүтэн нэр, хүйс, харьяалал, төрсөн огнооны талаарх мэдээллийг агуулсан хүчин төгөлдөр баримт бичиг эсвэл нотлох баримтыг бүрдүүлэн ирүүлж болно;
3. Дээд боловсролын диплом, гэрчилгээ (нотариатаар гэрчлүүлсэн хуулбар). Өргөдөл гаргагч нь их дээд сургуулийн оюутан бол өөрийн их сургуулиас олгосон хүлээгдэж буй төгсөлтийн гэрчилгээ эсвэл оюутны статусын гэрчилгээг ирүүлнэ;
4. Боловсролын дүнгийн хуулбар. Хятад, англи хэлнээс бусад хэл дээрх хуулбарыг хятад, англи хэл дээрх нотариатаар баталгаажуулсан орчуулгын хамт хавсаргана;
5. Хэлний ур чадварын гэрчилгээ. Хятад хэлээр заадаг хөтөлбөрт хамрагдах хүсэлт гаргагч нь тухайн хөтөлбөрийн хэлний ур чадварын шаардлагад нийцсэн HSK онооны хүчинтэй тайлан гаргаж өгөх ёстой. Хятад хэлнээс өөр хэлээр хичээл заадаг хөтөлбөрт хамрагдах бол тухайн зорилготой их сургууль нь өргөдөл гаргагчаас IELTS эсвэл TOEFL шалгалтын тайлан зэрэг тухайн хэлний мэдлэгийн гэрчилгээг шаарддаг;
6. Хятад эсвэл англи хэл дээр бичигдсэн сургалтын эсвэл судалгааны төлөвлөгөө (бакалаврт элсэх оюутнуудын хувьд 200-аас доошгүй үгтэй/тэмдэгтэй);
7. Санал болгох захидал. Бакалаврын дараах хөтөлбөрт хамрагдах эсвэл магистрантаар эрдмийн боловсрол эзэмших өргөдөл гаргагч нь профессор эсвэл дэд профессороос тодорхойлсон хятад эсвэл англи хэл дээр хоёр санал болгох захидлыг ирүүлнэ;
8. Урлаг эсвэл дизайны хөтөлбөрт хамрагдах өргөдөл гаргагч нь өөрийн бүтээлийг (видео, зураг гэх мэт) ирүүлнэ;
9. 18 нас хүрээгүй өргөдөл гаргагч нь Хятадад байгаа хууль ёсны асран хамгаалагчийнхаа хууль ёсны бичиг баримтыг бүрдүүлж өгөх ёстой;
10. Хятадад зургаан сараас дээш хугацаагаар суралцах хүсэлт гаргагч нь Гадаад иргэний биеийн байдлын шалгалтын хуудасны хуулбарыг (өргөдөл гаргагч нь Хятадын хорио цээрийн газраас хэвлэсэн баримт бичгийн эх хувийг англи хэл дээр бөглөж, хадгална) ирүүлнэ. Эрүүл мэндийн үзлэгт Гадаад иргэний биеийн үзлэгийн маягтанд тусгасан бүх зүйлс хамрагдах ёстой. Бүрэн бус бүртгэл тэмдэглэл эсвэл эмчийн гарын үсэггүй, эмнэлгийн албан ёсны тамга тэмдэггүй, эсвэл өргөдөл гаргагчийн лацадсан гэрэл зураг нь хүчингүйд тооцогдоно. Эмнэлгийн шинжилгээний хариу зургаан сар л хүчинтэй;
11. Өргөдөл гаргагч нь тухайн орон нутгийн олон нийтийн аюулгүй байдлын байгууллагаас (цагдаагийн газар гэх мэт) олгосон гэмт хэргийн бүртгэлгүй байдлын гэрчилгээг (эсвэл цагдаагийн газар чөлөөлөлтийн гэрчилгээ) ихэвчлэн өргөдөл гаргах өдрөөс өмнө зургаан сарын дотор гаргаж өгөх ёстой.

VII. Холбоо барих мэдээлэл

Ази

Тел: 0086-10-66093923

Имэйл: asia-admission@csc.edu.cn

Факс: 0086-10-66093972

Вебсайт: <http://www.campuschina.org>

Хаяг: Division of International Students Admission and Cooperation Programs, China Scholarship Council Level 13, Building A3, No.9 Chegongzhuang Avenue, Beijing, P.R China

Шуудангийн дугаар: 100044

Дэлгэрэнгүй мэдээллийг https://www.campuschina.org/content/details3_74776.html веб сайтаас үзнэ үү.